

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/045/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Цэрэнханд Утас: 99086371 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn Аудитор: Н.Гэрэлмаа Утас: 99782918 Цахим хаяг: gerelmaan@audit.gov.mn</p>
---	--

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр).....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр).....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр).....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр).....	9
Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	10
3.1 Залруулсан алдаа:.....	10
3.3 Албан шаардлага	11
3.4 Зөвлөмж	11
Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 7048-4030,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025.02.16

№

68

танай _____ -ны № _____ -т

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН
ТӨВИЙН ДАРГА С.БАТСАЙХАН
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус байгууллагын улсын төсвийн санхүүжилт өмнөх оноос 87,652.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд Эрүүл мэндийн яамнаас 5,569.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авсан байна.

822505000197

Бусад асуудал

Тайлант онд 1 хөтөлбөр, 4 зорилт, 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 6 арга хэмжээ бүрэн, 5 арга хэмжээ 95.0 хувь, 2 арга хэмжээ 90.0 хувь, нийт дүнгээр 96.5 хувиар биелүүлж, гүйцэтгэлийг хүргүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	580,133,611.84	538,646,980.72
33	АВЛАГА	48,007,655.74	2,099,331.12
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	645,344.57	645,344.57
335	Бусад авлага	30,473,460.17	1,453,986.55
3352	Хувь хүмүүсээс авах авлага	30,473,460.17	1,453,986.55
35	БАРАА МАТЕРИАЛ	532,125,956.10	536,547,649.60
351	Түүхий эд материал	454,489,559.40	455,017,452.90
35130	Эм боох материал	454,489,559.40	455,017,452.90
354	Хангамжийн материал	77,636,396.70	81,530,196.70
35410	Бичиг хэргийн материал	3,729,700.00	4,274,500.00
35420	Аж ахуйн материал	22,537,958.70	22,981,958.70
35430	Сэлбэг хэрэгсэл	9,324,000.00	9,324,000.00
35440	Түлш, шатах тослох материал	12,725,879.00	12,725,879.00
35450	Барилгын засварын материал	2,106,400.00	2,106,400.00
35470	Бусад хангамжийн материал	27,212,459.00	30,117,459.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,911,326,146.24	4,731,244,577.38
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,911,326,146.24	4,731,244,577.38
392	Биет хөрөнгө	4,797,846,146.24	4,617,764,577.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,411,392,478.00	4,377,799,978.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(118,987,106.12)	(182,408,332.40)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	76,684,000.00	75,220,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(60,234,347.20)	(68,457,847.24)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	673,389,364.89	610,343,211.62
39206	Хуримтлагдсан элэгдэл	(192,332,595.87)	(199,692,960.75)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,575,694.93	13,116,188.73
39208	Хуримтлагдсан элэгдэл	(30,641,342.39)	(8,155,660.58)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,036,037.00	-
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,036,037.00)	-
393	Биет бус хөрөнгө	113,480,000.00	113,480,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	113,480,000.00	113,480,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,491,459,758.08	5,269,891,558.10
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	25,335,165.18	57,714,726.57
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	25,335,165.18	57,714,726.57
413	Өглөг	25,335,165.18	57,714,726.57
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	18,922,702.95
4136	Бусад өглөг	25,335,165.18	38,792,023.62
41361	Байгууллагад төлөх өглөг	8,346,314.18	38,593,923.62
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,466,124,592.90	5,212,176,831.53
51	Засгийн газрын хувь оролцоо	5,466,124,592.90	5,212,176,831.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	281,217,975.40	281,217,975.40
51101	Өмч: - төрийн	281,217,975.40	281,217,975.40
512	Хуримтлагдсан үр дүн	5,152,473,758.00	4,901,258,856.13
51210	Өмнөх үеийн үр дүн	5,152,473,758.00	5,155,206,617.50
51220	Тайлант үеийн үр дүн	-	(253,947,761.37)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	32,432,859.50	29,700,000.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,491,459,758.08	5,269,891,558.10

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,802,666,690.18	849,695,649.27
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,027,734,139.18	5,719,149.27
120	Нийтлэг татварын бус орлого	5,027,734,139.18	5,719,149.27
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	326,260,270.40	5,569,149.27
120009	Бусад орлого	-	150,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	774,932,551.00	843,976,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	773,212,551.00	843,976,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	773,212,551.00	843,976,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,720,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	944,803,071.19	1,098,986,240.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	944,803,071.19	1,098,986,240.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	908,645,173.58	1,088,627,202.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	546,414,706.25	668,837,929.86
210101	Үндсэн цалин	352,495,826.04	383,493,305.62
210102	Нэмэгдэл	133,198,697.59	217,988,904.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,454,000.00	35,489,000.00
210104	Урамшуулал	40,266,182.62	31,866,719.42
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,956,936.14	70,834,974.90
210201	Тэтгэврийн даатгал	41,049,738.24	40,750,874.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,412,954.82	8,809,176.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,609,382.27	6,414,203.40
210204	Ажилгүйдлийн даатгал	2,045,557.33	2,972,601.50
210205	Эрүүл мэндийн даатгал	9,839,303.48	11,888,120.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,980,657.48	114,077,193.03
210301	Гэрэл, цахилгаан	2,723,128.49	5,633,738.39
210302	Түлш, халаалт	47,075,126.99	104,128,254.64
210303	Цэвэр, бохир ус	1,182,402.00	4,315,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,566,873.00	18,295,500.00
210401	Бичиг хэрэг	1,265,900.00	781,800.00
210402	Тээвэр, шатахуун	17,350,000.00	13,840,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,605,273.00	1,891,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,345,700.00	1,782,500.00
2105	Нормативт зардал	11,471,822.60	26,983,106.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,471,822.60	24,972,606.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	2,010,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	300,000.00	200,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	200,000.00
210604	Урсгал засвар	300,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	15,134,450.00	8,251,950.00
210702	Дотоод албан томилолт	15,134,450.00	8,251,950.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,850,741.00	153,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,032,741.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	450,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	335,000.00	120,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	33,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	195,968,987.11	180,993,548.02
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	195,968,987.11	180,993,548.02
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,157,897.61	10,359,038.22
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,888,851.00	-

Говь-Алтай аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,549,046.61	10,359,038.22
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,549,046.61	10,359,038.22
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,720,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	4,857,863,618.99	(249,290,591.26)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	79,246.16	4,657,170.11
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	79,246.16	4,657,170.11
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(79,246.16)	(4,657,170.11)
5	НИИТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	4,857,784,372.83	(253,947,761.37)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	758,043,700.00	861,015,351.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	17,038,851.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	17,038,851.00
120009	Бусад орлого	-	17,038,851.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	758,043,700.00	843,976,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	756,323,700.00	843,976,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	756,323,700.00	843,976,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,720,000.00	-
2	НИИТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	739,143,500.00	861,015,351.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	739,143,500.00	861,015,351.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	719,874,453.39	833,767,461.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	538,327,229.66	611,040,736.39
210101	Үндсэн цалин	344,581,058.08	335,551,129.05
210102	Нэмэгдэл	131,012,287.40	208,133,887.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,108,000.00	35,489,000.00
210104	Урамшуулал	42,625,884.18	31,866,719.42
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,044,412.73	80,689,991.80
210201	Тэтгэврийн даатгал	49,480,401.64	50,605,890.90
210202	Тэтгэмжийн даатгал	4,911,061.28	5,939,596.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,742,804.55	9,283,783.40
210204	Ажилгүйдлийн даатгал	3,340,945.91	2,972,601.50
210205	Эрүүл мэндийн даатгал	8,569,199.35	11,888,120.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,114,900.00	83,689,783.59
210301	Гэрэл, цахилгаан	2,723,128.49	3,789,353.52
210302	Түлш, халаалт	41,209,369.51	76,911,217.07
210303	Цэвэр, бохир ус	1,182,402.00	2,989,213.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,589,023.00	19,194,600.00
210401	Бичиг хэрэг	3,013,950.00	1,205,400.00
210402	Тээвэр, шатахуун	17,466,000.00	13,840,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,278,773.00	2,152,200.00

**Говь-Алтай аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	169,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,830,300.00	1,828,000.00
2105	Нормативт зардал	18,600,897.00	25,664,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,367,897.00	23,762,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,233,000.00	1,902,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,718,000.00	5,083,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	226,000.00	442,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	4,465,000.00
210604	Урсгал засвар	3,492,000.00	176,000.00
2107	Томилолт, зочны зардал	15,134,450.00	8,251,950.00
210702	Дотоод албан томилолт	15,134,450.00	8,251,950.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,345,541.00	153,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,197,541.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	450,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	335,000.00	120,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	33,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	330,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,269,046.61	27,247,889.22
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	16,888,851.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	16,888,851.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,549,046.61	10,359,038.22
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,549,046.61	10,359,038.22
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,720,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	18,830,000.00	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	281,217,975.40	32,432,859.50	5,152,473,758.00	5,466,124,592.90
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	281,217,975.40	32,432,859.50	5,152,473,758.00	5,466,124,592.90
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	2,732,859.50	2,732,859.50
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	281,217,975.40	32,432,859.50	5,155,206,617.50	5,468,857,452.40
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(2,732,859.50)	-	(2,732,859.50)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(253,947,761.37)	(253,947,761.37)
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	281,217,975.40	29,700,000.00	4,901,258,856.13	5,212,176,831.53

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	843,976,500.00	850,656,312.78	(6,679,812.78)	100.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	843,976,500.00	850,656,312.8	(6,679,812.78)	100.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	843,976,500.00	833,767,461.78	10,209,038.22	98.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	612,379,700.00	611,040,736.39	1,338,963.61	99.8
210101	Үндсэн цалин	335,608,200.00	335,551,129.05	57,070.95	100.0
210102	Нэмэгдэл	208,233,900.00	208,133,887.92	100,012.08	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,918,300.00	35,489,000.00	(6,570,700.00)	122.7
210104	Урамшуулал	39,619,300.00	31,866,719.42	7,752,580.58	80.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,694,000.00	80,689,991.80	4,008.20	100.0
210201	Тэтгэврийн даатгал	50,605,900.00	50,605,890.90	9.10	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	5,939,600.00	5,939,596.00	4.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,283,800.00	9,283,783.40	16.60	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,974,600.00	2,972,601.50	1,998.50	99.9
210205	Эрүүл мэндийн даатгал	11,890,100.00	11,888,120.00	1,980.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90,814,500.00	83,689,783.59	7,124,716.41	92.2
210301	Гэрэл, цахилгаан	3,382,700.00	3,789,353.52	(406,653.52)	112.0
210302	Түлш, халаалт	86,815,500.00	76,911,217.07	9,904,282.93	88.6
210303	Цэвэр, бохир ус	616,300.00	2,989,213.00	(2,372,913.00)	485.0
2104	Хангамж, бараа материалын зардал	19,883,900.00	19,194,600.00	689,300.00	96.5
210401	Бичиг хэрэг	1,229,400.00	1,205,400.00	24,000.00	98.0
210402	Тээвэр, шатахуун	14,968,900.00	13,840,000.00	1,128,900.00	92.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,442,000.00	2,152,200.00	289,800.00	88.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	201,900.00	169,000.00	32,900.00	83.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,041,700.00	1,828,000.00	(786,300.00)	175.5
2105	Нормативт зардал	25,665,600.00	25,664,400.00	1,200.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,865,100.00	23,762,000.00	(1,896,900.00)	108.7
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,800,500.00	1,902,400.00	1,898,100.00	50.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,097,400.00	5,083,000.00	14,400.00	99.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	442,000.00	442,000.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,479,400.00	4,465,000.00	14,400.00	99.7
210604	Урсгал засвар	176,000.00	176,000.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	8,500,000.00	8,251,950.00	248,050.00	97.1
210702	Дотоод албан томилолт	8,500,000.00	8,251,950.00	248,050.00	97.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	941,400.00	153,000.00	788,400.00	16.3

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	86,100.00	-	86,100.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	405,300.00	-	405,300.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	302,000.00	120,000.00	182,000.00	39.7
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	103,800.00	33,000.00	70,800.00	31.8
210807	Газрын төлбөр	43,400.00	-	43,400.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	800.00	-	800.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	16,888,851.00	(16,888,851.00)	
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	16,888,851.00	(16,888,851.00)	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	16,888,851.00	(16,888,851.00)	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖИХ ЭХ ҮҮСВЭР	843,976,500.00	833,617,461.78	10,359,038.22	98.8
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	843,976,500.00	833,617,461.78	10,359,038.22	98.8
131001	Улсын төсвөөс санхүүжих	843,976,500.00	833,617,461.78	10,359,038.22	98.8
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	22.00	20.0	2.00	90.9
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	11.00	2.00	84.6
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00	-	100.0

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 958,446.7 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

3.1 Залруулсан алдаа:

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Санхүүгийн байдлын тайланд өмнөх үеийн үр дүнг 2,732.9 мянган төгрөгөөр дутуу,
- Санхүүгийн үр дүнгийн тайланд эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлыг 2,010.5 мянган төгрөгөөр илүү, нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлыг 2,010.5 мянган төгрөгөөр дутуу,
- Мөнгөн гүйлгээний тайланд орлогыг 17,038.8 мянган төгрөгөөр дутуу, цэвэр мөнгөн гүйлгээг 17,038.8 мянган төгрөгөөр илүү тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна.
- Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 1,693,245.5 мянган төгрөгийн 77 мэдээллээс, цалингаас бусад 5 саяаас дээш орлого, зарлага, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн нийт 936,664.5 мянган төгрөгийн 35 мэдээллийг тус тус мэдээлээгүйг нөхөн байршууллаа.

Залруулагдаагүй нийт 11,286.2 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 11,286.2 мянган төгрөгийн 4 зөрчил² илэрсэнд 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 2 зөвлөмжийг хүргүүлсэн.

3.2 Төлбөрийн акт

1. Няравын ажил хавсран гүйцэтгэдэг нян судлалын лаборантад өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар "хязгаарлалттай" дүгнэлт авсан байхад санхүүгийн тайланг үнэн зөв гаргасан гэх үндэслэлээр 3 сарын үндсэн цалинтай тэнцэх 1,131.2 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал, тушаал шийдвэргүйгээр 300.0 мянган төгрөгийн цалингийн нэмэгдэл нийт 1,431.2 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.3-т "Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон 1,431.2 мянган төгрөгийг Төрийн сан дахь Га.Аудитын орлогын 100050000982 тоот дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт хүргүүлсэн.

3.3 Албан шаардлага

1. Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор өмнөх жилүүдэд дутагдсан гэх 12,725.9 мянган төгрөгийн түлш, шатах тослох материал оршин байхгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 20 дугаар зүйлийн 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тооллогоор дутагдсан бараа материалын үлдэгдэлд дотоод хяналт хийж, арга хэмжээ авч ажиллан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нэг. Төсвийн зарцуулалттай холбоотой

Илрүүлэлт: Зардлын эдийн засгийн ангилал зөрчин ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 9,855.1 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Ангилал шинэчлэн батлах тухай"-тай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсөвт зохицуулалт хийхдээ харьяалагдах дээд шатны төсөв захирагчид саналаа хүргүүлэн, зөвшөөрөл авсны үндсэн дээр баталсан төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулан шийдвэрлэж байх.

Хоёр. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор Алтай хотын тохижилт үйлчилгээний газарт 113,480.0 мянган төгрөгийн 567 м2 газрыг шилжүүлэх шийдвэр гарсан боловч дээрх хөрөнгийг шилжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", "Говь-Алтай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 16 дугаар тогтоолын хавсралт"-тай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шийдвэрийн дагуу газар шилжүүлэхгүй байгаа шалтгаан нөхцлийг тогтоож, холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлэх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Говь-Алтай аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Говь-Алтай аймгийн Зоонозын өвчин судлалын төв	Санхүүгийн байдлын тайланд өмнөх үеийн үр дүнг 2,732.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	2,732.9	-	-	1	2,732.9	1	2,732.9	-	-	-	-
	Санхүүгийн үр дүнгийн тайланд эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлыг 2,010.5 мянган төгрөгөөр илүү, нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлыг 2,010.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	2,010.5	-	-	1	2,010.5	1	2,010.5	-	-	-	-
	Мөнгөн гүйлгээний тайланд орлогыг 17,038.8 мянган төгрөгөөр дутуу, цэвэр мөнгөн гүйлгээг 17,038.8 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.	1	17,038.8	-	-	1	17,038.8	1	17,038.8				
	Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 1,693,245.5 мянган төгрөгийн 77 мэдээллээс, цалингаас бусад 5 саяаас дээш орлого, зарлага, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн нийт 936,664.5 мянган төгрөгийн 35 мэдээллийг тус тус мэдээлээгүй байна.	1	936,664.5	1	936,664.5	-	-	1	936,664.5	-	-	-	-
Дүн		4	958,446.7	1	936,664.5	3	21,782.2	4	958,446.7	-	-	-	-

Говь-Алтай аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Говь-Алтай аймгийн Зоонозын өвчин судлалын төв	Няравын ажил хавсран гүйцэтгэдэг нян судлалын лаборантад өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар "хязгаарлалттай" дүгнэлт авсан байхад санхүүгийн тайланг үнэн зөв гаргасан гэх үндэслэлээр 3 сарын үндсэн цалинтай тэнцэх 1,131.2 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал, тушаал шийдвэргүйгээр 300.0 мянган төгрөгийн цалингийн нэмэгдэл нийт 1,431.2 мянган төгрөгийг олгосон байна.	1	1,431.2	1	1,431.2	-	-	-	-	-	-
	Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор 12,725.9 мянган төгрөгийн түлш, шатах тослох материал байхгүй байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-
	Зардлын эдийн засгийн ангилал зөрчин ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 9,855.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	9,855.0	-	-	-	-	1	9,855.0	-	-
	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор Алтай хотын тохижилт үйлчилгээний газарт 113,480.0 мянган төгрөгийн 567м2 газрыг шилжүүлэх шийдвэр гарсан боловч дээрх хөрөнгийг шилжүүлээгүй байна.	1	-	-	-	-	-	-	1	-	-
Дүн		4	11,286.2	1	1,431.2	1	52,029.0	2	9,855.0	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	НИЙТ		1			1			